

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН “ОЮУТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН АШИГЛАЛТАД
МОНГОЛ УЛСЫН ЭРХ АШГИЙГ ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ” ҮҮРЭГ БҮХИЙ ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-21

1.“Нотлох баримт цуглуулах тухай” Түр хорооны тогтоолын төсөл	5-6
2.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох	6-15
3.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох	15-21

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 10 дугаар сарын 01-ний өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 15 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, Д.Пүрэвдаваа;
Чөлөөтэй: М.Бадамсүрэн, Б.Жаргалан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн Түр хорооны дарга О.Батнайрамдал хуралдаанаар хэлэлцэх 1, 2, 3 дугаар асуудлуудыг хаалттай хэлэлцэх горимын санал гаргав.

О.Батнайрамдал: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	1
Бүгд:	7

85.7 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, хуралдаан хаалттай горимд шилжив.

Хуралдаан 14 цаг 20 минутаас 14 цаг 44 минутад хаалттай горимоор хуралдав.

Нэг. “Нотлох баримт цуглуулах тухай” Түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Түр хорооны дарга О.Батнайрамдал “Нотлох баримт цуглуулах тухай” Түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

О.Батнайрамдал: “Нотлох баримт цуглуулах тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
-------------	---

Татгалзсан: 1

Бүгд: 7

85.7 хувийн саналаар Түр хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Төслийн судалгаа, үнэлгээний газрын дарга Д.Батмөнх, Чанар, бүтээмжийн асуудал хариуцсан менежер Д.Ядамжав, Нэгдсэн стратеги, санхүүгийн удирдлагын газрын дарга Б.Батбаяр, Төслийн үнэлгээний хэлтсийн менежер Ү.Чулуунбаатар, “Эрдэнэс Оюу толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Ганхүү, мөн компанийн ерөнхий менежер Б.Батбаатар, Геологи, уул уурхайн хэлтсийн менежер Л.Өнөрбаатар, Санхүү, шинжилгээний хэлтсийн менежер Б.Баяр-Өлзий, Хуулийн хэлтсийн менежер Ж.Наранпүрэв, “Оюу толгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Э.Баясгалан, Э.Мэндтүвшин, Н.Цэрэнбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээллийг ажлын хэсгийн ахлагч, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, С.Зулпхар, Э.Болормаа нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Сангийн яамны Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Төслийн судалгаа, үнэлгээний газрын дарга Д.Батмөнх, Чанар, бүтээмжийн асуудал хариуцсан менежер Д.Ядамжав, Нэгдсэн стратеги, санхүүгийн удирдлагын газрын дарга Б.Батбаяр, Төслийн үнэлгээний хэлтсийн менежер Ү.Чулуунбаатар, “Эрдэнэс Оюу толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Ганхүү, мөн

компанийн ерөнхий менежер Б.Батбаатар, Геологи, уул уурхайн хэлтсийн менежер Л.Өнөрбаатар, Санхүү, шинжилгээний хэлтсийн менежер Б.Баяр-Өлзий, Хуулийн хэлтсийн менежер Ж.Наранпүрэв, “Оюу толгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Э.Баясгалан, Э.Мэндтүвшин, Н.Цэрэнбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээллийг Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Амарбаясгалан нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, С.Зулпхар нарын тавьсан асуултад Түр хорооны дарга О.Батнайрамдал, Сангийн сайд Б.Жавхлан, “Эрдэнэс Оюу толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Ганхүү нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Түр хорооны нээлттэй хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 1 цаг 11 минут үргэлжилж, 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

О.БАТНАЙРАМДАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
14 цаг 15 минут.*

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Батнайрамдал: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Оюу толгойн бүлэг ордын ашиглалтын асуудлаарх Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2025 оны 10 сарын 01-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир, Энхбатын Болормаа, Пүрэвжавын Ганзориг, Баярмагнайн Баярбаатар, Шинэбаярын Бямбасүрэн, Отгоншарын Батнайрамдал гэсэн 54,5 хувийн ирцтэй хуралдаан эхэлж байна.

Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд, “Хянан шалгагч томилж, ажлын даалгавар батлах тухай” тогтоолын төсөл, “Шинжээч томилох тухай” тогтоолын төсөл, “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”, “Нотлох баримт гаргуулах тухай” тогтоолын төсөл, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх, өөрчлөх асуудлаарх хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох. Үүний өмнө нь Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан Стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын талбайн хил зааг доторх ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг Онтрэ компанийн хувьцааны төрийн эзэмшил хувь, хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж, холбогдох бусад асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох.

Хэлэлцэх асуудлаар, асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Өнөөдрийн хуралдаанд Сархадын Зулпхар гишүүн ирж, ирц 63,6 хувь болсон байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх Түр хорооны хянан шалгагч томилж, ажлын даалгавар батлах, Шинжээч томилох, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай нь Түр хорооны дотоод асуудал бөгөөд Хянан шалгах түр хорооноос томилогдон ажиллах хянан шалгагч, шинжээч нарт хөндлөнгөөс нөлөөлөх магадлалтай учраас тус тогтоолын төслүүдийг хэлэлцэх хаалттай хуралдааны горимын санал гаргаж байна. Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүддээ гэж хэлэхэд энэ 6 асуудлын зөвхөн хянан шалгагч томилох, шинжээчидтэй холбоотой асуудлыг хаалттай, бусад нь бүгд нээлттэй явуулна гэсэн үг.

Тэгэхээр Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 8.8 дахь, 8.3 дахь хэсгийг үндэслэн хуралдааныг түр хаалттай горимд шилжүүлэх горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтад

бэлдсэн байна. Тэгье, санал хураалт. Нийт гишүүдийн 85,7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Хуралдааныг хаалттай горимд шилжүүлнэ үү.

Хуралдаан 14 цаг 20 минутаас 14 цаг 44 минутад хаалттай горимоор хуралдав.

О.Батнайрамдал: Болоогүй байна, одоо нэг юм байгаа. Бидний өнөөдрийн хэлэлцэх 4 дэх асуудал бол мөн Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл байгаа.

Нэг. “Нотлох баримт цуглуулах тухай” Түр хорооны тогтоолын төсөл

Тодруулбал өмнө нь бид 26 байгууллагаас нотлох баримт гаргуулахаар хэлэлцэж, тогтоол баталсан боловч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас нэлээдгүй нотлох баримт цуглуулах шаардлага үүссэн тул “Нотлох баримт цуглуулах тухай” тогтоолын төслийг хэлэлцэхээр Түр хорооны хуралд оруулж байна. Хуулийн үндэслэл нь Улсын Их Хурлын хянан шалгах Хяналт шалгалтын тухай хуулийн 37.1 Түр хорооны хуралдаанаар тусгай шалгалтын сэдвийн хүрээнд хамаарах нотлох баримтыг цуглуулах, гэрчээр дуудах, шинжээч, хянан шалгагчийг томилох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоол батална. Санал хураалтад цөөнх болсон гишүүд тухайн асуудлаар үндэслэлээ дэлгэрэнгүй тайлбарлаж 3 удаа хүртэл санал хураалгаж болно гэсэн заалтыг үндэслээд, тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тогтоол Нотлох баримт цуглуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

1 дүгээрт, Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх сэдвийн хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас нотлох баримтын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2 дугаарт, хавсралтад дурдсан нотлох баримтуудыг холбогдох байгууллагаас хуульд заасан шаардлагад нийцүүлэн тогтоосон хугацаанд бүрэн гүйцэт гаргаж өгөх үүрэгтэй болохыг дурдсугай.

3 дугаарт, хавсралтад дурдсан нотлох баримтуудыг холбогдох байгууллагаас хуулийн шаардлага хангуулан гаргуулж авах, мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах, хянан шалгах түр хорооны тусгай шалгалтыг цаг хугацаанд нь, чанартай гүйцэтгэж, дүгнэлт тайлангаа сонсголд танилцуулахыг хянан шалгагч нарт үүрэг болгосугай. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хянан шалгах Түр хорооны дарга Батнайрамдалд даалгасугай гэсэн Түр хорооны тогтоолын төслийг та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье? Байхгүй байна. Бүгдээрээ санал хураалтад бэлдье. Тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт

нийт гишүүдийн 85,7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүдэд баярлалаа. Дараагийн асуудалдаа орцгооё.

Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох

Дараагийн асуудал Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан Шивээ толгой Жавхлант нэртэй ашиглалтын ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эзэмшдэг Онтрэ компанитай төрийн эзэмшлийн танилцуулна. Танилцуулгатай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Ажлын хэсгийг оруулъя. ажлын хэсэг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням, эд нар бүгд байгаа юм уу, байгаа юм уу? Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Цолмон, Эрдэнэс Монгол хариуцлагатай хязгаарлагдмал компанийн гүйцэтгэх захирал Наранцогт, ингээд болчихсон юм уу? Дамдинням сайд ингээд болчихсон тийм ээ, болон бусад ажлын хэсгийг, бусад гишүүдийг оруулъя. Надад нэрс нь алга байна шүү дээ. Нэмэлтээр гэж байгаа юм байна тийм үү? Нэмэлт, наадах чинь ондоо ажлын хэсэг байхгүй юу. Эрдэнэс Оюу толгой компаниас нэмэлтээр ерөнхий менежер Батбаатар, Геологи, уул уурхайн хэлтсийн менежер Өнөрбаатар, Санхүү шинжилгээний хэлтсийн менежер Баяр-Өлзий, Хуулийн хэлтсийн менежер Наранпүрэв, Оюу толгой Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Баясгалан, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Мэндтүвшин, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Цэрэнбат, 1 ТУЗ-ын гишүүн байна тийм ээ, болчихсон уу? Эрдэнэс Оюу толгой. Эрдэнэс Монголоос уншигдсангүй. Эрдэнэс Монгол компаниас нэмэлтээр Төслийн судалгаа, үнэлгээний газрын дарга Батмөнх, Чанар, бүтээмж, хариуцсан менежер Ядамжав, Тулга албан тушаал байхгүй байна, Тулга гээд, Төслийн үнэлгээний хэлтсийн менежер Чулуунбаатар, Нэгдсэн стратеги, санхүүгийн удирдлагын газрын дарга Батбаяр. Өөр? Бүрэлдэхүүн бүгд ирсэн байна.

Танилцуулгыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням, микрофоныг өгье.

Г.Дамдинням: Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны эрхэм гишүүд ээ,

Ерөнхий сайдын 2025 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 73 дугаар захирамжаар стратегийн ач холбогдол бүхий Оюу толгойн бүлэг ордын талбайн хил зааг дотор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг Онтрэ компанийн хувьцааны төрийн эзэмших хувь хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, холбогдох бусад асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахлан ажиллаж байна. Ажлын хэсэг дараах бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Татварын ерөнхий газрын дарга, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Үндэсний геологийн албаны дарга, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга нараас бүрдсэн бөгөөд ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Эрдэнэс Монгол хариуцлагатай хувьцаат компанийн гүйцэтгэх захирал томилогдсон.

Ерөнхий сайдын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсанаар ажлын хэсгийн ахлагчийн зүгээс Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс Оюу толгой ХХК-тай албан уулзалтыг зохион байгуулж, тодорхой үүрэг чиглэлийг өгөн ажиллаж байна. Эрдэнэс Оюу толгой ХХК-ийн хувьд Онтрэ ХХК-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүдтэй холбогдох хууль зүйн асуудлаар тодорхой санал, дүгнэлтүүдийг боловсруулахыг үүрэг болгосон бөгөөд Ажлын хэсгийн хуралдаанаар уг дүгнэлтүүдээ танилцуулж, цаашид хэлэлцээг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахад онцгой анхаарч ажиллаж байна. Түүнчлэн Онтрэ ХХК болон тус компанийн эзэмшдэг ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой хууль, эрх зүйн асуудлыг ажлын хэсэг нарийвчлан судлах үүргийг холбогдох яамдын төлөөлөл, компаниудын хуулийн багт үүрэг болгосон. Ойрын хугацаанд тодорхой үр дүн гаргаж, нэгдсэн танилцуулга бэлтгэхэд бэлэн болсон байгаа бөгөөд энэ танилцуулгыг бид бүхэн хэлэлцээрийн явцтай уялдуулж, Улсын Их Хурал болон Засгийн газрын түвшинд танилцуулна гэсэн ийм төлөвлөгөөтэй байна.

Эрдэнэс Монгол ХХК-ийн хувьд хэлэлцээнд ашиглах санхүүгийн тооцоо, хувилбаруудын үр дүнг тооцож, танилцуулахыг үүрэг болгосон байгаа. Энэ хүрээнд Эрдэнэс Монгол компани өнгөрсөн 5 сарын хугацаанд Оюу толгой төслийн санхүүгийн тооцоо, техник, эдийн засгийн үндэслэл, материалд нарийвчлан дүн шинжилгээ хийсэн байгаа. Үүний үр дүнд алдаатай тооцооллуудыг засварлаж, Монголчууд Оюу толгой төсөл дээр анх удаа өөрсдийн санхүүгийн загварчлалыг боловсруулсан байгаа. Цаашид Орано Майнинг компанитай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээрийн зарчмын дагуу хэлэлцээг зохион байгуулж, санхүүгийн загварт үндэслэн хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаад байгаагаа мэдэгдье.

Уг боловсруулсан загварчлал нь олон улсын томоохон хөрөнгө оруулалтын банк, санхүүгийн байгууллагын ашигладаг FAST standard-д нийцсэн бөгөөд мөн загварчлалыг боловсруулагдахдаа Торонтогийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй Антре гоулд компанийн хөрөнгө оруулагчдадаа зориулсан тоо баримтад суурилж, харьцуулсан шинжилгээ хийснээрээ илүү бодитой, илүү онцлог болсон гэдгийг энд дуулгая. Ажлын хэсгийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах үүднээс Монгол Францын хамтарсан ураны төслийн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсан хэлэлцээ хийсэн зарчимтай ижил загвараар уг хэлэлцээг зохион байгуулахаар Ажлын хэсэг төлөвлөж байгаа бөгөөд тухайлсан асуудлаар хариуцах 1 дүгээрт гэрээ эрх зүйн, 2 дугаарт Эдийн засаг, санхүү, татварын, 3 дугаарт уул уурхай, байгаль орчны чиглэлээр дэд ажлын хэсгүүд байгуулахаар шийдвэрлэн зохион байгуулалтаа хийгээд ажиллаж байна. Ажлын хэсгийн хуралдаанаар ажлын хэсэг төлөөлөн байгууллага бүрийн төлөөлөлд хууль зүй, нөөц тооцоололтой холбоотой тодорхой үүрэг өгч богино хугацаанд үр дүн гаргахыг үүрэг болгон ажиллаж байна.

Нийт Хянан шалгах түр хороонд ажиллаж байгаа эрхэм гишүүддээ хандаж хэлэхэд Оюу толгой холбоотой олон 4 чиглэлээр Монгол Улсын Засгийн газар хэлэлцээр хийхээр ингээд ажиллаж байгаа бөгөөд эдгээр хэлэлцээрүүд нь бүгдээрээ уялдаа холбоотой. Тэгээд Монголчуудад өөрийнхөө улс оронд бидний төлөөлж байгаа энэ ард түмэндээ Баялгийн сандаа илүү их үр өгөөжийг авчруулах чиглэлд бид бүхэн энэ удаад нэгдсэн зохион байгуулалттайгаар, нэгдсэн удирдлагатайгаар ажиллаж байгаагаа онцолж хэлье. Эрдэнэс, Оюу толгой хувьцаат компанид Монголыг төлөөлөн сууж байгаа 3 төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Эрдэнэс Монгол ХК нь Эрдэнэс Оюу толгой ХК Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам зэрэг

яамнууд, байгууллагууд төрийн бүтцийн байгууллагууд бүгд нэгдсэн удирдлагатай, нэгдсэн бодлоготойгоор зохион байгуулалтад орж ажиллаж байгаа.

Энэний хүрээнд бид бүхэн өмнө нь хийгдэж байсан ажлууд яагаад үр дүнгээ өгөхгүй байсан тал дээр анализ хийж үзсэн. Санаа үр дүн бол ерөөсөө юу гэж гарч байгаа вэ гэхээр тухайлсан компани болгон өөр өөрийнхөө чиглэлээр жижиг, жижиг ажлын хэсгүүд зохион байгуулж, харилцагч талтай буюу бидний түнштэй очиж ажилласаар нэгдсэн уялдаа зохион байгуулалтгүй ажиллаж ирсэн ийм л сул тал байгаад байгаа гэж харагдаж байгаа. Тэгээд бидний хувьд одоо энэ ажлаа нэгтгэж зохион байгуулаад, яригдаж байгаа асуудлуудын зарим асуудлуудыг Монгол Улсад нэн шаардлагатай байгаа асуудлуудыг тэргүүн эгнээнд, Монгол Улсад ирээдүйд богино, дунд болон богино хугацаандаа үр өгөөжтэй байгаа асуудлуудыг эрэмбэлэх дарааллаар бид бүхэн энэ ажлуудыг хийж байгаа.

Ажлын хүрээнд нийт хянан шалгалтын хороо, Батнайрамдал даргадаа хэлэхэд манай энэ ажлын хэсэгт ажиллаж байгаа энэ компаниуд ажил хэргийн шугамаараа тусгайлсан үүрэг аваад, зарим тохиолдолд бид нууцлалын гэрээтэйгээр маш эрчимтэйгээр санхүүгийн тооцооллууд, моделиудаа гаргаад, хууль, эрх зүйн хувьд гарч болох эрсдэлүүдийг бүгдийг нь тооцоолсон бэлтгэл ажлыг хангасан байгаа. Тэгээд би хэрвээ шаардлагатай хэлэлцээрийн тактикой холбоотой асуудлуудыг ярина гэвэл тусдаа горимоор хэдүүлээ яриад явчихвал зүйтэй байна гэсэн ийм л танилцуулгыг хийе дээ даргаа. Баярлалаа Нэмэлт тодорхой асуудлууд дээр манай ажлын хэсгийн гишүүдээс тодруулж асуух зүйл байвал асууя, надаас бас асууж болно.

О.Батнайрамдал: Дамдинням сайдад баярлалаа. Бидний ойлгож байгаагаар Рио Тинто компанитай хэд хэдэн хэлэлцээр давхар явж байгаа гэж ойлгож байгаа. Зээлийн хүү, Онтрэ, тэрнээс гадна тийм арбитр дээр явж байгаа асуудлууд гэх мэтчилэн. Тэгэхээр миний ойлгосноор та нийтэд нь зангидаж, нэгдсэн зохион байгуулалтад орж, өөрөө ахалж явна гэж ойлгож байгаа. Тэгэхээр Дамдинням сайдаа бүгдээрээ хурал дээр нээлттэй ярьж байгаад нэг ийм зүйлийг тохирьё. Хурал дээр та өөрөө заавал ирж байгаарай, төлөөллөө битгий явуулаарай бүгдээрээ яг. Тэгэхгүй болохоор төлөөллөө явуулаад л эхлэхээр яг ажил цалгардсан, яг эсвэл ийм асуудал гараад байгаа юм. Тэгэхээр нэгдсэн зохион байгуулалтад орно гэдэг маш зөв гэж харж байгаа. Яагаад гэвэл яг үнэнийг хэлэхэд урд өмнө нь ч гэсэн дандаа салангид тус тусдаа сайдууд ахалчихсан, тэгээд хоорондоо уялдахгүй, тэгээд энэ бүгд хэлэлцээрүүд бол та хэллээ хэлэлцээрийн зүгээс ч гэсэн Монгол Улсын, нэг л Монгол Улсын Засгийн газар хэлэлцээрт орж байгаа. Тэгэхээр нэгдсэн зохион байгуулалтаар хангаж байгаад талархалтай хандаж байгаа.

Тэгэхээр бидний зүгээс ерөөсөө хүсээд байгаа зүйл энэ ажил дээр цаг алдалгүй яваач л гэж байгаа юм. Яг энэ цаг мөчид та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Рио Тинто Монголиа компаниас Онтрэ-гийн 2 лицензийг Оюу толгой компани руу шилжүүлж авах процесс 3 сараас хойш явж байгаа. Монголын татварын албан дээр татварын бодолт хийлгэхээр албан тоотоор хандаад, сүүлдээ татварын бодолтын албан тоот нь ирэхгүй болохоор шүүхэд хандсан, Онтрэ шүүхэд хандсан ийм тохиолдол байна. Тэгэхээр энэ дээр 1 дүгээрт та ажлын хэсэг ахалж байгаа хүний хувьд байр сууриа илэрхийлэх хэрэгтэй. Яагаад гэвэл энэ лиценз шилжиж болох юм уу?

Энэ 2 лиценз Монгол Улсын Засгийн газартай гэрээ хэлэлцээр хийхгүйгээр, Улсын Их Хуралд ч танилцуулагдаж, эцэслэн батлагдахгүйгээр энэ Онтрэ компанийн эзэмшилд байгаа Жавхлант, Шивээ толгой 2 лиценз Рио-д Оюу толгой компани руу шилжиж болох уу? Энэ дээр тодорхой хариултыг эхлээд авъя. Дамдинням сайдын микрофон.

Г.Дамдинням: 1 дүгээрт ажлын хэсгийн өмнөх хуралдаан дээр ирээгүй шалтгаан бол Монгол Улсын Засгийн газрын өгсөн үүрэг даалгаврын дагуу БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны удирдлагуудтай Эдийн засаг, хөгжлийн сайд бөгөөд Тэргүүн шадар сайдтай цуг очиж гаалийн экспортыг нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл одоогийн байдлаар гарч байгаа өдрийн 1500-1700 машины тоог 2500 хүрэх хэмжээний хэлэлцээр хийх ажлаар томилолттой явсан учраас эрхэм гишүүд, түр хорооны гишүүдээсээ уучлал хүсье. Гэхдээ яалт ч үгүй ингээд ажил байсан учраас та бүхэн маань хүлээж авч ойлгоно байх. Түүнээс биш ямар нэг шалтгаангүйгээр би хурал таслахгүй, байнга оролцоно, мөн зайлшгүй шаардлагатай бол ажлын хэсгийн ахлагчид хэлж, чөлөөгөө аваад явж байна гэдгээ хэлье. Та бүхэн маань хуралдаанаа тодотгож, тодорхой хугацаанд зарлаж өгч байвал их сайн байна урьдчилаад. 2 дугаар асуудал долоо хоног болгон хуралдана гэж ойлгож байгаа. Зарим үед нь манай асуудал орохгүй байх үе байж магадгүй тийм ээ, зөвхөн санхүүтэй холбоотой асуудлууд яригдаж магадгүй байгаа учраас. Энийгээ ажлын хэсгийн ахлагчидтайгаа ярилцаад явчихъя.

2 дугаар асуудал Батнайрамдал гишүүнээ, даргаа, тэгээд манай эрхэм гишүүд, нийт ард түмэн, бид нэг Монголчууд, бид энэ ажилд ажиллаж байгаа, хэлэлцээрт орж байгаа Монгол залуучууд бүгдээрээ эх орондоо хайртай. Монголын нийт ард түмэнд хүртэгдэх өгөөж бүгдэд нь илүү олдох ёстой гэдгийн төлөө бид бүхэн санаа зорилго нэгтэй, эх орондоо хайртай ийм зарчмаар ажиллаж байгаа. Тийм учраас энэ Онтрэ компанид байгаа 2 лиценз тэр компани руу шилжих боломжгүй. Манай ажлын хэсгийн үзэж байгаа байр суурь эхний ээлжид энэ асуудлуудаа тодорхой шийдэж явтал энэ гэрээнүүд хийгдэхгүй нэг.

2 дугаарт бид бүхэн яг өмнө нь ч би танд Их Хурлын индэр дээрээс нээлттэй, шууд хэлж байсан, олон нийтэд дахиад хэлье. Онтрэ-тэй холбоотой энэ 2 лиценз дээр Монгол Улс тусад нь хөрөнгө оруулалтын гэрээ хийх ёстой гэсэн ийм хатуу байр суурьтай байгаа. Лиценз шилжих асуудалд Монгол Улс оролцох ёстой. Энд 2 нюанс байдаг. Хэдийгээр энэ Рио Тинто компани болон Онтрэ Гоулд компаниуд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахаас өмнө хийчихсэн гэрээнийхээ үүргийг одоогийн хөрөнгө оруулалтын гэрээнд шингээж ойлгуулах гээд олон улсын арбитрын шийдвэр гарсан ч гэсэн, олон улсын арбитрын шийдвэр нь лицензтэй холбоотой хэсэг дээр Монголын хууль тогтоомжийн дагуу явна гэдэг шийдвэр гаргачихсан учраас энд эрсдэл байхгүй л гэж ойлгох ёстой. Бид татварын байгууллага ч тэр, манай лиценз хариуцаж байгаа агентлаг ч тэр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас ч тэр энэ лицензүүдийг шилжүүлэх асуудал байхгүй. Товчхон тийм л байна.

О.Батнайрамдал: Баярлалаа. Яг энэ асуудлыг бид маш тодорхой нэг талдаа гаргах ёстой юм. Парламент дээр Хянан шалгах түр хороо байгуулагдсан. Бид ч гэсэн Улсын Их Хурлын хянан шалгах Хяналт шалгалтын тухай хуулийнхаа хүрээнд бид ажиллах болно. Монгол Улсын Засгийн газар гүйцэтгэх засаглалын хувьд Дамдинням сайд ахлаад ингээд хэлэлцээрт орох яг үндсэн хуулийн этгээд. Тэгэхээр бид парламентын түвшинд хэлэлцээрийн тактик руу орохгүй. Яагаад гэвэл энэ

Засгийн газрын хийх ажил. Харин бид Хянан шалгах түр хороо Хяналт шалгалтын тухай хуулиараа ерөнхий сонсголоо зохион байгуулна.

Мөн та түрүүн хэллээ. Монгол Улсын эрх ашгийг хамгаалж байгаа яг үндсэн ард түмний төлөөлөл болох Улсын Их Хурал, тэр дундаа Улсын Их Хурал дээр байгуулагдсан Хянан шалгах түр хороо, Монгол Улсын Засгийн газар бид бүгдээрээ л Монгол Улсын эрх ашгийг хамгаалж, нэг талдаа л байгаа. Тэгэхээр тэрүүн дээр байр суурь хамтдаа гэдгээ илэрхийлэх ёстой, илэрхийлж байгаа юм. Байр суурь нэг байна. Бид хэлэлцээр дээр Засгийн газрыг дэмжиж ажиллана. Засгийн газар Монгол, бид нэг суурь, нэг байр суурийг хамгаалж, яг Монгол Улсын эрх ашгийн төлөө л ажиллах болно. Зүгээр бид хэрвээ ажил цалгардвал, асуудал хойшилбол, эс үйлдэхүй харагдвал бид чимээгүй байхгүй. Парламент ч гэсэн өөрөө тэгэх ёстой, хяналт шалгалтаа хийх ёстой, Засгийн газраа шахах ёстой. Тэр ажлаа давхар хийх болно.

Асуудлаа бид цаг тухайд нь шийдээд, энэ Монгол Улсын эрх ашигт нэн чухал асуудлаа шийдээд явбал бид бүхэн нэг л зорилгын төлөө хамтдаа явж байгаа юм. Тийм учраас ажлын хэсгийг Засгийн газраас ахалж байгаа Дамдинням сайдад хариуцлагатайгаар хэлье. Монгол Улсын парламент дээр бид Хянан шалгах түр хорооны хүрээнд ч гэсэн Засгийн газрыг хэлэлцээрийн түвшинд дэмжиж бид ажиллана. Гэхдээ бид та бүхний хэлэлцээрийн тактикийн нарийвчлал руу орохгүй. Яагаад гэвэл бид хэлэлцээрт орох субъект биш байгаа юм. Тэгэхээр заавал хэлэлцээрийн деталийг бол бид парламентын Хянан шалгах түр хороон дээр ярих шаардлагагүй гэж үзэж байна. Тэгэхээр шаардлагагүй. Та тэрийг тусдаа Засгийн газар дээрээ өөрийнхөө ажлын хэсэг бусад сайд нартайгаа эцэслэж явах ёстой.

Харин бид бүхэн энэ талаас шахаж, яг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль тогтоомжийнхоо дагуу явах болно. Гишүүдэд, асуулт асуух гишүүд нэрсээ өгцгөөе? Болормаа гишүүнээр тасалъя. Зулпхар гишүүний микрофон.

С.Зулпхар: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Бид ер нь яах вэ зүгээр ингээд түр хороо хуралдсаар байгаад, мэдээллээ сонссоор байгаад энэ явцад нь Засгийн газар ажлын хэсэг байгуулаад, тодорхой шуурхай ажиллах ийм чиглэл гараад, тэгээд тал талдаа л ажиллаж байна. Би Дамдинням сайдтай санал нэг байна. Бид нэг Монголчууд гэж байгаа, гарцаа байхгүй бид бүгдээрээ л нэг Монголчууд. Гэхдээ энэ дээр бид хамтын манлайлал үзүүлэхгүй бол болохгүй юм байна гэдэг талаас нь бүгдээрээ асуудалд хандаж байгаа. Хууль тогтоох жишээ нь эрх бүхий байгууллагын хувьд энэ 2019 онд Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн тэр боломжийг л бид ашиглаж байгаа шүү дээ. 2019 онд бол ер нь парламентын хянан шалгах тэр чиг үүргийг илүү шинэ түвшинд аваачих зорилгоор энэ Хянан шалгах түр хороо байгуулж, ажил хийдэг ийм боломжийг нь тэрүүгээр тогтоочихсон юм байгаа юм.

Тэгээд энэ бол тодорхой асуудлаар бид энд уг нь шууд Англиас нь орчуулбал мөрдөн шалгах түр хороо шүү дээ энэ чинь. Яах вэ мөрдөн шалгах гэдэг нь мэдээж хэрэг цагдаагийн байгууллагаас ялгаатай. Тэгэхдээ тодорхой асуудлыг нарийн бид хянаж шалгаад, мэдээллүүдээ аваад, мэргэжлийн улсуудын зөвлөгөөн дээр тулгуурласан байдлаар тогтоол гаргадаг, дүгнэлт гаргадаг нэг ийм л зүйл юм байгаа юм. Яг одоо энийг харин хэрэгжүүлдэг, гэхдээ энэнээс өмнөхийг нь хэрэгжүүлэх үүрэг нь угаасаа Засгийн газарт байгаа. Бидний гарт 92, 103 гэсэн тогтоол байгаа юм. 103 дугаар тогтоолын 1 дэх заалт нь яах вэ хэрэгжихсэн, бусад нь ингээд хэрэгжих явцтай явж байна гээд. Тэгэхлээр энэ үүднээс нь аваад үзвэл хамтын

манлайлал дээрээ бид баттай зогсох нь гэдгийг таны амнаас, хариуцлагатай сайдын амнаас сонсож байгаадаа талархалтай байна. 2 асуулт асуух гээд байна.

Би зүгээр өнгөрсөн уулзалтууд дээр тодорхой хариултууд авсан боловч таныг ажлын хэсгийн гишүүний хувиар асууя гэж бодож байна. Энэ Оюу толгой компани энэ Онтрэ-гийн талбай руу нэвтрэлт хийчихсэн гэж байгаа юм. Тэгэхээр энэ нэвтрэлт хийсэн асуудлыг нэг талаар нь жишээ нь захиргааны процесс нь зөв явчихсан юм шиг, шууд аваад лиценз шилжээгүй байдлыг нь харахаар зэрэг энэ чинь захиргааны процесс угаасаа алдаатай явчихсан юм шиг нэг ийм зүйл байгаад байгаа юм. Энэ дээр ажлын хэсэг дээр та бүхэн ярьсан уу, ямаршуу байр суурьтай байгаа вэ гэсэн?

2 дахь асуудал энэ би сая буруу ойлгочихсон уу? Та бол угаасаа мэдээлэлтэй байгаа байх. Энэ хэлэлцээрийн хүрээнд уг нь 103 дугаар тогтоолоор чинь энэ засаглалын асуудлыг нь эргэж харна гэхийхсэн байгаа шүү дээ. Энэ Оюу толгой төслийн ТУЗ дээрх манай засаглалын оролцоо, ер нь зүгээр Оюу толгой төслийн хүрээ дэх энэ засаглалын асуудлыг цаашдаа эрх тэгш байх энэ зарчим дээр суурилсан байдлаар сайжруулах чиглэлээр та бүхэн ярьж байна уу, энэ хэлэлцээрт байгаа юу? Би сая энэ тэрийг сонсоогүй учраас зориуд асууж байна. Баярлалаа.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүний асуултад Дамдинням сайд хариулъя, микрофон.

Г.Дамдинням: Зулпхар гишүүн их маш чухал асуулт асууж байна. Энэ Онтрэ компанийн харьяанд байгаа 2 лицензийн талбайд бэлтгэл нэвтрэлт гэдэг зүйл хийгдсэн. Уулын ажлын төлөвлөгөөг нь 2025 оны 1 дүгээр сард батлаад өгчихсөн байна лээ. Тэгээд би тэрэнд эргэлзээтэй байгаа, тийм, тэрийг бид энэ Хянан шалгах хороон дээрээ ярих ёстой байх. Бэлтгэл нэвтрэлт гэдэг олборлолтын үйл ажиллагаа биш. Манай ажлын хэсэг дээр энэ асуудал яригдсан. Хэр хэмжээний хүдэр байгаа юу, эсвэл ямар хэмжээний зүйлүүд тэр нэвтрэлт, бэлтгэл нэвтрэлтийн ажлууд хийж ингэж судалгаа шинжилгээ хийсэн байна вэ гэдгийг хэмжилт хийгээд тооц гэдэг үүрэг даалгавар өгөгдчихсөн явж байгаа. Тооцоо нь гарч ирнэ, хийгдэнэ. Тэнд олборлолт явагдахгүй ийм хэмжээтэй байгаа. Хайгуул аль эрт хийгдчихсэн.

Засаглалтай холбоотой асуудал бид 103-ын хүрээнд ярьж байгаа. Оюу толгой компанид Монголыг төлөөлж ажиллаж байгаа 3 хүн хангалттай, хангалтгүй ажиллаж байгаа, зохион байгуулалтгүй ажиллаж байгаа, тайлан өгөхгүй байгаа, удирдамжаар хангахгүй байгаа олон асуудлууд бий. Энэ асуудлуудыг бид ярьж байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд зарим нь их сайн ажилладаг, зарим нь алга болдог ийм түүхүүдийг бүгдээрээ мэдэж байгаа. Тийм учраас зайлшгүй нэгдсэн мэдээллээр ажлын хэсгийг хангаж, энэ төр засгаа хангаад яв гэдэг чиглэлийг өгч байгаа. Мөн хараат бус гишүүдийг томилуулах тухай асуудлуудыг бид мөн энэ хэлэлцээрийнхээ түвшинд аваад ингээд явж байгаа.

Нэг шүүгчийн шийдвэртэй холбоотой асуудал байдаг. Энэ нь манай энэ Төлөөлөн удирдах зөвлөлийн 3 гишүүний хаалт, хамгаалалт тавих, зогсоох энэ эрх, үүргийг цуцалсан ийм байдал руу оруулсан, эрх зүйн нэг ийм нөхцөл байдал бий. Бид нэг зүйлийг ойлгох ёстой Оюу толгойн гэрээ бол өөрчилж болдоггүй гэрээ биш, өөрчилж болдоггүй гэрээ биш. Өөрчлөх асуудал ярих бол бид ярих бүрэн эрхтэй. Гэрээн дээрээ энэ заалтууд нь байгаа. Монгол Улсынхаа давуу талд, аль болох давуу талыг үүсгэх чиглэлээр ажиллаж байна. Та бүгдтэйгээ санал нэг байна. Тэгээд хэлэлцээртээ орно, хэлэлцээртээ энүүхэндээ л маш товчоор хэлэхэд тэр хүмүүсийн

түрүүнд шийдэх гэж хүсэж байгаа асуудал бидний хамгийн сүүлд шийдэхийг хүсэж байгаа асуудлуудтай давхцаж байдаг. Бидний хамгийн түрүүнд шийдэх гэж оролдож байгаа зүйлс тэдний хувьд хамгийн сүүлд шийдэх тухай асуудал байж байдаг. Тэгэхээр би дэлгэрэнгүй ингээд хамаагүй нөгөө тактикийн холбоотой юмнуудаа дараа нь ажлын хэсгийн даргатай зөвлөлдөөд ингээд явъя л гэсэн ийм л бодолтой байна.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Баярлалаа. Их тодорхой хариултууд өгч байгаад. Нөгөөтээгүүр яах вэ, сая нөгөө засаглалтай холбоотой зүйл дээр мэдээж хараат бус нэг гишүүн томилох нь чухал гэж ойлгож байгаа. Тэрнээс гадна энэ чинь уг нь 3 оролцогчтой байж байгаад энэ төсөл чинь 2 оролцогчтой болчихоод, нөгөө тал чинь 6-уулаа болж аваад л, бид 3-уулаа л болчихсон юм байна лээ шүү дээ. Би тэгж л ойлгож байгаа. Бид бүгдээрээ тэгж ойлгож байгаа. Тэгэхээр бид ингээд хараат бус шинжээч орлоо ч гэсэн энэ дээр бид нөгөө нэг санал өгөх тэр эрхийн асуудлыг ярихгүй бол болохгүй юм байна гэж ойлгосон. Тэр нь нөгөө хориг тавих эрх шүү дээ veto right гээд. Тэгэхлээр энэ асуудлыг та бүхэн тэр засаглалын хүрээнд ярих уу? Хэрвээ энэ асуудлыг ярихгүй бол бид ахиад л магадгүй 6, 4 гэдэг ийм харьцаан дээрээс саналаа бид бол цаашдаа тэр төсөв мөнгөтэй холбоотой, хөрөнгө оруулалттай холбоотой ямар нэгэн шийдвэр гаргах бол ахиад л нөгөө тал давамгайлаад л ингээд явах ийм байна л даа. Гол нь нөгөө эрх тэгш байхын зарчмыг хангах тэр саяын зүйлүүдийг ярьж байна уу, энийг яах юм бэ л гэж асууж байна?

О.Батнайрамдал: Дамдинням сайдын микрофон хариулт.

Г.Дамдинням: Би түрүүн танилцуулга дээрээ хэллээ. Бидний хувьд veto тавих эрх авах бас нэг нөхцөл нь шинэ хөрөнгө оруулалтын гэрээ гээд байгаа тэр концептод байгаад байгаа юм Зулпхар гишүүнээ тантай санал нэг байгаа.

О.Батнайрамдал: Онтрэ-ийн талбай руу нэвтэрч орсон тэрүүн дээр Дамдинням сайдаа сайн судлаарай. Онтрэ бол Канадын хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагддаг компани бүх мэдээлэл нь нээлттэй, ил тод байдаг. Нээлттэй компанийн тэр Канадын хөрөнгийн бирж дээр гарсан мэдээллүүдээс харвал тэр таны 2025 оны 1 сард зөвшөөрлөө авснаас өмнө олон ажил хийгдсэн байдаг шүү. Тэр нь аль түрүүн гарсан байдаг. Тэгэхээр энийг та он сарын дараалалтайгаар яг зөвшөөрлөө яс авч, цаг хугацаандаа хийсэн үү гэдгийг нь нягтлах ёстой.

2 дугаарт ажлын хэсгийнхэн бүгдээрээ байна, та бүхэн энийг тэмдэглээд аваарай. Онтрэ, Оюу толгой хоёр Арбитрын шүүх дээр явж байгаад, Арбитрын шүүхийн шийдвэр гэдэг агуулгаар 2025 оны 02 сарын 05-нд хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. 56 хуудас гэрээ Онтрэ-ийн веб сайтаас та бүхэн бүгдээрээ олж болно. Энэ гэрээн дээр маш олон асуудлыг хоорондоо шийдэж авсан байдаг шүү. Өнөөдөр хөрөнгө оруулалтын гэрээгээр бид 34 эзэмшдэг мөртөө, 34 хувьд ноогдох зэсийн баяжмалаа бид борлуулах ямар ч эрх байхгүй. Гэтэл Онтрэ компани ашгаа, эдийн засгийн ашгаа 20, 80 гэж хуваагаад, 20 хувьдаа оногдох зэсийн баяжмалаа маркетинг хийж борлуулах эрхээ авсан байдаг шүү. Дээрээс нь Онтрэ мөнгө гаргадаггүй, Онтрэ дээр гарч байгаа бүх зардлыг Оюу толгой төлдөг. Оюу толгой төлөөд, буцаад Онтрэ-ээс зээлсэн, зээлжих хэлбэрээр хүүтэй буцааж авдаг мөнгөн урсгалаар. Энэ хүүгээ бол Канадын бодлогын хүү дээр нэмэх нь 2 хувь буюу

өнөөдрийн тооцооллоор яг өнөөдрийн ханшаар аваад үзвэл 6,7 хувийн хүүтэй Онтрэ зээл авч байгаа. тэрийг харж үзэх хэрэгтэй.

Онтрэ 6,7 хувиар зээл авч болоод байхад яагаад бид энэ толгой компанид нь 11 хувиар одоо хүртэл төлж байгаа юм. Энэ өөрөө зах зээлийн зарчим биш шүү дээ. Бид хөрөнгө оруулалтын гэрээ байгуулаад 30 жил болж байгаа. Энэ 30 жилийн гэрээ байгуулаад 16 дахь жил рүүгээ орж байна. 16 жилийн туршид бид гэрээн дээр нэг ч өөрчлөлт оруулаагүй шүү. 2009 онд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ гэж нэг гэрээ байгаа. Яг тэр өдөр дараагийн долоо хоногт энэ хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсны 17 дахь яг жил нь тохиох гэж байгаа, 10 сарын 6-нд буюу дараагийн нэг дэх өдөр тохионо. Энэ гэрээ байгуулагдахад хэн ч анзаараагүй Хувь нийлүүлэгчдийн гэрээ гэж давхар гэрээ байгуулагдсан шүү. Эрдэнэс MGL гээд Монголын тал, Оюу толгой, тэгээд 2 Рио Тинтогийн 100 эзэмшил цаасны 2 компани. Тэгэхээр энэ гэрээн дээр энэ бүх санхүүжилттэй холбоотой асуудлууд гарсан. Энэ гэрээ өөрөө цаашаагаа хүчинтэй юу, Улсын Их Хурлаар орох ёстой байсан уу, үгүй юу, энэ гэрээ 2011 онд 6 сарын 8-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нөгөө талаас 9 онд огт гэрээнд өөрчлөлт оруулахгүй гэххээд яагаад 11 онд нөгөө талаас гэрээнд Монголын тал бараг мэдэхгүйгээр өөрчлөлт орж байгаа юм.

Гэтэл бид гэрээнд өөрчлөлт оруулах болохоор ямар ч боломжгүй болоод явчихдаг. Тэгэхээр ер нь бараг 16 жилийн туршид гэрээндээ өөрчлөлт оруулахгүй явсан цөөхөн улсын нэг Монгол Улс байх л гэж бодож байгаа юм. Тэгэхээр энийг ажлын хэсгийн дарга Дамдинням сайд бусад орны жишигтэй харьцуулаарай, 10, 20 жилээр гэрээ яваад нэг ч өөрчлөлт оруулахгүй явдаг тийм тохиолдлууд дэлхий дээр хэд байдаг юм бэ? Ялангуяа ийм уул уурхайн төслүүд дээр. Болормаа гишүүн асуулт асууна, Болормаа гишүүний микрофоныг өгье.

Э.Болормаа: Та бүхнийхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд өнөөдөр салбарын сайд хүрэлцэн ирсэнд баярлалаа. Энэ ажлын хэсгийнхээ мэдээллийг дэлгэрэнгүй танилцуулж байгаад, бүгдээрээ ажил хэрэгчээр л энэ дээрээ үр дүнд хүрэх нь бидний гол зорилго байгаа. Тэгээд мэдээж Оюу толгой төслийг ярихад нийгэмд маш их олон талын байр суурь яригддаг. Манай энэ түр хороонд бараг олонх нь байна уу даа тэр чигээрээ анх удаа сонгогдсон гишүүд байгаа. Өмнөхийг үгүйсгэх гэсэн зорилгоор бус, урдах юмаа засаж сайжруулъя л гэсэн ийм зорилгоор байгаа. Мэдээж манай олон Монгол залуучууд Оюу толгой төсөл дээр ажиллаж байна. Шилдэг боловсон хүчин бас тэнд бэлтгэгдэж байна. Тэгэхдээ аливаа нэг юм хар, цагаан гэж хуваагдахаас илүүтэйгээр яаж бид илүү сайжруулах вэ гээд гэдэг дээр анхаарч байгаа. Тэгэхээр энэ дээр ч гэсэн ажлын хэсэг ийм байдлаар хандаж байгаа байх гэдэгт итгэж байна.

Ажлын хэсэг манай энэ түр хороо хэдий Онтрэ болон зээлийн хүү бууруулах гэсэн ийм хүрээ хязгаар дотор боловч Дамдинням сайд та өөрөө өмнө нь Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байсан. Өмнөх энэ 92 дугаар тогтоол болон 103 дугаар тогтоолын хэрэгжилттэй нягт уялдаатай баймаар байна. Бид Оюу толгой гэдэг асуудалдаа ер нь багцаар нь хандах ёстой. Манай энэ түр хороо бол зүгээр цаг хугацаанд хавчигдаж, ялангуяа энэ Онтрэ болон зээлийн хүү дээр ач холбогдол өгч, тэгээд үр дүн гаргачих юм сан гэсэн байдлаар хандаж байгаа, орхигдсон байсан асуудал. Гэхдээ энэ 92 болон 103 дугаар тогтоол гэдэг 2 Улсын Их Хурлаар, Монгол Улсын Их Хурлаар батлагдсан эдгээр тогтоолуудын бүрэн дүүрэн хэрэгжилтэд нарийн анхаарч ажилламаар байна. Тэгээд үүнийгээ манай энэ Түр хорооны ажилтай уялдуулж ажиллах ёстой гэдэг зүйл гарч ирж байна. Тэгэхээр энэ дээр ажлын хэсэг ямар байр суурьтай байгаа вэ?

Өмнө нь Засгийн газар бол миний мэдэхийн эдгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангах ажлын хэсэг гээд давхар байсан. Тэгэхээр салбарын сайд та эдгээр тогтоолуудыг хэрэгжүүлэхэд тусгай ажлын хэсгүүд байгаа юу, энийг хэрхэн уялдуулж ажиллаж байгаа вэ гэдгийг тодруулъя?

О.Батнайрамдал: Болормаа гишүүний асуултад хариулъя. Дамдинням сайд микрофон.

Г.Дамдинням: Болормаа гишүүн аягүй чухал яг л нөгөө нэгдсэн бодлогоор нь харж ажиллаарай гэдэг санаа хэлж байх шиг байна. Тэгээд би яг түрүүн танилцуулгадаа хэлсэн. Би нөгөө 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байгаа юм. Тэгээд одоо бол манай ажлын хэсгийн хүрээнд үндсэндээ миний ахалж байгаа Онтрэгийн ажлын хэсэг болон Сангийн сайдын ахалж байгаа нөгөө зээлийн хэлэлцээрийн ажлын хэсэг, мөн цаана нь нөгөө арбитрай хэлэлцээр хийж байгаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын ажлын хэсэг бүгд багтаж ажиллаж байгаа Болормаа гишүүнээ. Тэгээд нэгдсэн уялдаагаар хангаж явахгүй бол угаасаа болохгүй юм байна лээ. Хуучин манай алдаа юу байсан бэ гэхээр харж байхад би түрүүн хэлсэн ингээд нэг нэгээрээ тухайн, тухайн асуудал руу үсрээд орчихоор зэрэг нөгөө талдаа давуу байдал үүсгээд байдаг ийм тал байсан. Тэгээд би таны санааг ойлголоо. Тэгээд энийг анхаарч ажиллаж байгаа.

О.Батнайрамдал: Болормаа гишүүн тодруулъя.

Э.Болормаа: Салбарын сайддаа хандаж хэлэхэд бид нийгэмд газрын ховор элемент ч юм уу, энэ салбарын өөр шинэ хөгжил дэвшлийг ярьж байна л даа. Олон нийт энэ Оюу толгой, Тавантолгой, Эрдэнэт одоо өгчихсөн энэ лицензүүдийн өгөөжийг нэн тэргүүнд харж байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлын зүгээс миний хувьд гишүүний хувьд яг л энэ зүйлийг нэн тэргүүнд харж байгаа. Үндсэн хуульд зааснаараа байгалийн баялгийн энэ өгөөжийн дийлэнх нь иргэдэд ирж байна гэдгийг бид баталгаатай харуулсны дараа олон нийтээсээ дэмжлэг авна шүү. Тэгэхээр салбар ер нь бараг бусад бүх шинэ юм гэж байсныгаа ер нь түр хойш нь тавиад, энэ Онтрэ, Оюу толгой, Тавантолгой гэдгээ бүүр нэгд тавиад эд нарыгаа цэгцлэх дээр анхаараач, ийм эрэмбэ дараатай ажиллаарай гэж хүсье.

О.Батнайрамдал: Санал хэллээ гэж ойлголоо. Болормаа гишүүнтэй санал нэг байна. Тэгэхээр бид ер нь олон нийтийн ч гэсэн маш том хүлээлт байгаа шүү. 2009 онд бид хамгийн анхны хөрөнгө оруулалтын гэрээгээ алдаатай ч, оноотой ч Оюу толгойн гэрээгээ бид байгуулсан. Энэ шинэ 126 гишүүнтэй парламент Ораногийн гэрээг хийсэн. Тэгээд дараагийн Онтрэ-гийн гэрээг бид цаг хугацаанд нь багтааж яаралтай хийх ёстой. Энэ бол Монгол Улсын эрх ашиг, мөн олон нийтийн захиалга л гэж хэлмээр байна. Тэгэхээр одоо бид Онтрэ дээр гэрээ байгуулахдаа 2009 оны хөрөнгө оруулалтын гэрээн дээр давтагдсан алдааг бид давтаж болохгүй. Тэрнээс ахиц дэвшил гаргаж, энэ 16 жилийн туршид бид тэндээс юу олж мэдэв, ямар алдаа гарсан юм, ямар алдааг засах боломжгүй юм бэ, яаж өөрчлөх ёстой юм.

2 дугаарт Онтрэ өөрөө Оюу толгой хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байгаа юм. Дөнгөж энэ онд 25 онд байгуулсан, Оюу толгойтой байгуулчхаад тэгвэл яагаад Монголтой байгуулахгүй байгаа юм бэ? Тэгэхээр тэдний, энэ 2 үндсэн гэрээн дээр алдаа, оноог нь суралцаад, Онтрэ Оюу толгойтой бол манай 2009 оны гэрээтэй харьцуулахад хавь илүү, хэдэн барьцаар илүү сайн гэрээ хийж чадсан байгаа шүү. Тэгэхээр бид ч гэсэн тэрүүнд нь л яг адилхан эн тэнцүү л үзэх ёстой. Тэгж байж бид

Монгол Улсын эрх ашгийг өөрсдийн хэмжээнд хамаг байдгаараа л хангах ёстой. Яагаад гэвэл хэзээ нэгэн цагт буцаад бид хэрхэн, ямар гэрээ байгуулсан бэ гэдэг дүнгээ тавиулна. Тийм учраас энэ дээр бид байр суурь нэгтэй, хамтдаа, өөрсдийнхөө хэмжээнд хамгийн сайн хувилбараараа гэрээ байгуулах ёстой л гэж үзэж байгаа. Тэгээд Дамдинням сайдад амжилт хүсье. Гишүүд асуулт хариулж, үг хэлж дууслаа. Ажлын хэсэгт баярлалаа. Дараагийн хуралдаандаа, дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсэгт баярлалаа.

15.24 цаг

Гурав.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох

Дараагийн ажлын хэсэг, адилхан хүмүүс байгаа юу? Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээлэл танилцуулна.

Танилцуулгатай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Сангийн сайд Жавхлан, Санхүү, бодлогын, Сангийн яамны Санхүү, бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Амарбаясгалан, Эрдэнэс Оюу толгой компанийн гүйцэтгэх захирал Ганхүү, Эрдэнэс Монгол компанийн захирал, гүйцэтгэх захирал Наранцогт, Эрдэнэс Оюу толгой компаниас нэмэлтээр ерөнхий менежер Батбаатар, Геологи, уул уурхайн хэлтсийн менежер Өнөрбаатар, Санхүү, шинжилгээний хэлтсийн менежер Баяр-Өлзий, Хуулийн хэлтсийн менежер Наранпүрэв, Оюу толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Мэндтүвшин, Оюу толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Цэрэнбат, Оюу толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Баясгалан, бүгдээрээ ирсэн байна. Эрдэнэс Монголоос нэмэлтээр байсан уу? Мөн Эрдэнэс Монголоос өмнөх ажлын хэсэгт орсон, нэмэлтээр орсон гишүүд хүрэлцэн ирсэн байна. Ажлын хэсэг 100 хувь ирсэн байна.

Танилцуулгатай, танилцуулга мэдээлэл аль микрофон бэ? 2 номерын микрофон танилцуулгаа хийе. Амарбаясгалан дарга.

Б.Амарбаясгалан: Хянан шалгах түр хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Амарбаясгалан байна. Ерөнхий сайдын 25 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 67 дугаар захирамжаар байгуулсан энэ ажлын хэсэг маань энэ Оюу толгойн төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж, санал боловсруулах ийм үүрэг ажлыг авсан байгаа. Мөн Оюу толгойн асуудлаар ажиллаж байгаа энэ 4 ажлын хэсгүүдээс гаргаж буй зөвлөмжийг нэгтгэж, нэгдсэн байр сууринд хүрсний үндсэн дээр хэлэлцээр хийх тактик боловсруулах нь зүйтэй гэж өчигдрийн хурлаар үзсэн.

Тухайлбал хүүг бууруулах асуудлын хүрээнд гаргаж байгаа санал, зөвлөмжүүд нь арбитрын ажлын хэсгээс гаргасан саналуудтай нийцэж байгаа эсэх, мөн Оюу толгойн хүрээнд байгуулагдсан бусад ажлын хэсгийн төлөвлөгөө, тактикийг уялдуулах гэх зэрэг асуудлуудыг зангидах шаардлагатай байгаа гэдгийг Ажлын хэсгийн төлөөллүүд ярилцсан байгаа. Мөн энэ дэд ажлын хэсгүүдээс авч

байгаа, хэрэгжүүлж байгаа энэ арга хэмжээнүүдийг долоо хоног бүр нэгтгэгдэж танилцуулах, ажлын хэсгүүдийг 2 долоо хоног тутам хуралдуулж, үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах чиглэлээр ажиллаж байна.

Энэ хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх энэ дэд ажлын хэсгийг байгуулагдаад, нийт 2 удаа хуралдсан байгаа. Энэ дэд ажлын хэсгээс холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар өгч, шаардлагатай мэдээлэл, судалгааг хийлгээд явж байна. Ажлын хэсгээс энэ урьдчилсан байдлаар 3 асуудлыг хөндөх нь зүйтэй гэсэн байр суурьтай ажиллаж байгаа. Үүнд, хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг буур бууруулах асуудлаар хуримтлагдсан хүүтэй холбоотой асуудлаар энэ зээлийн хүүг хэлэлцэх хугацааг 7 жил байгааг өөрчлөх асуудлаар авч хэлэлцье гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Мөн хэлэлцээрийн баг, удирдамж, баримтлах зарчмуудыг бид эхний байдлаар гаргаад ирчихсэн байгаа бөгөөд энэ 4 ажлын хэсгээс нэгдсэн төлөвлөлтийн дагуу авч хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулж, асуудлуудаа тухай бүр танилцуулахаар төлөвлөж байна.

Энэ 3 хөндөх асуудлууд дээр дэд ажлын хэсгээс пойнт, кэйсүүд гаргаад ирчихсэн байгаа. Тэгэхдээ нээлттэй явж байгаа болохоор яг одоохондоо хэлэлцэхийг нь тухай бүр ажлын хэсгийн даргатай зөвлөлдөөд явах ингээд саналтай явж байна.

О.Батнайрамдал: Жавхлан сайд нэмэлтээр хариулт байгаа юу, болсон уу? 3 номерын микрофон.

Б.Жавхлан: Бид өчигдөр нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй ажлынхаа ер нь явцыг нэг дүгнээд, цаашаа ямаршуу тактикийг, ямаршуу байрлалтай хэлэлцээрүүддээ үргэлжлүүлэх вэ гэдгийгээ ярилцсан байгаа. Тэгээд үндсэндээ өмнөх хэлэлцээрт бэлтгэх, хэлэлцээр хийх ажлын хэсэг бүрэлдэхүүнүүд маань 2 хэсэг болоод яваад байсан. Энэ удаа хэдүүлээ 2, хэдийгээр 2 ажлын хэсэг байгаа ч гэсэн нэг дор зангидаж явъя. Тэр нь Уул уурхайн яам байх нь зөв. Өөрөөр хэлбэл тус тусдаа биш, хоорондоо уялдаа холбоотой байж хэлэлцээрийнхээ тактикаа их зөв уялдуулж ингэж үр дүнд хүрэх нь чухал. Тийм учраас яг жигүүр жигүүрээ дор дороо маш сайн бэлтгэлтэй байгаад, хэлэлцээрийнхээ үр дүнтэй уялдуулж, тактикаа яаж, ямар үед алийг нь түлхэх вэ, алийг нь хойш нь татах вэ энэ бүх юмнуудаа уялдуулъя гээд, ингээд чиглэлийн яам нь буюу Уул уурхай, эрдэс баялгийн яам маань ерөнхийдөө ахлаад явах зөв. Зээлийн хүүгийн хэсэг дээр Сангийн яам бүрэн бэлэн байна. Хаана нь урд нь гараад явах вэ, хаана нь хойшоо суух вэ гэдгийгээ нэгдсэн байдлаар нөгөө том гэр дотроо ярилцъя гэсэн байгаа. Тэгэхээр яг саяын танилцуулсан асуудал яг зээлийн хүүгийн асуудлаа л бид танилцууллаа гэж ойлгоорой.

О.Батнайрамдал: Баярлалаа. Тэгэхээр зээлийн хүү, ялангуяа бид бүхний Оюу толгой холбоотой асуудлаар хамгийн тулгамдсан цаг хугацааны хувьд бид зайлшгүй уралдах ёстой асуудал бол зээлийн хүү байгаад байгаа юм л даа. Ямар ч байсан тэр 11 онд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа өөрчилсөн, энэ миний гарт хувь нийлүүлэгчдийн гэрээ байна л даа. Тэгэхээр энэ гэрээний 11.3.Ё-д 7 жил тутам хүүгээ өөрчлөх гээд боломж. Тэгэхээр энэ боломжоо бид заавал ашиглаж, үр дүн гаргах ёстой. Яагаад гэхлээр бидний үндсэндээ ноогдол ашиг авахгүй байгаа үндсэн шалтгаан энэ өндөр зээлийн хүүтэй л холбоотой шүү дээ. Энэний санхүүгийн тооцооллыг Сангийн яамныхан бүгдээрээ байна, энэ Эрдэнэс Монгол, Эрдэнэс Оюу толгой бүгдээрээ л та бүхэн санхүүгийн тооцоолол дээр суусан байгаа. Санхүүгийн тооцооллоос, мөнгөн урсгалаас нь харвал ерөөсөө л энэ өндөр зээлийн хүүгээс болоод, энэ зээлийн хүүгийн эргэн төлөлтөөс болоод л бид ноогдол ашиг 37, 38 он,

тэрнээс наашгүй байгаа шүү дээ. Тэгэхээр энийг бид эрхээ ашиглаад буулгаж чадвал ноогдол ашгаа огцом наашлуулах боломж байна. Энэ дээр л бид заавал хийх ёстой шүү. Энэ дээр л заавал үйлдэл хийх ёстой шүү.

Энэ дээр нэг зүйл байгаа юм л даа. 18 онд бид энийг өөрчлөх анхны боломж нь байсан. Тэр үед төслийн явц өөрөө маргаантай байсан. Ойролцоогоор нэг төслийн уул уурхайн тэр далд уурхайн бүтээн байгуулалт 47, 8 хувьтай л байсан юм байна лээ. Манай зээлжих зэрэглэл өнөөгийн түвшнээс доогуур байсан. Эдийн засаг өнөөдөр 25 тэрбумтай байгаа бол тэр үед 13 орчим тэрбум доллар л байсан юм байна лээ. Тэрүүнтэй харьцуулахад бидэнд өнөөдөр бүх талаараа боломж нь байгаа шүү. Эдийн засаг 2 дахин томорсон, зээлжих зэрэглэл 2 шат ахисан, төслийн явц өөрөө 99,8 хувьтай явж байхад бид хэлэлцээр хийж чадахгүй бол яг үнэнийг хэлэхэд арчаагүй болоод л үлдэнэ шүү.

Тийм учраас энэ боломжоо бид ашиглах ёстой. Миний гарт Рио Тинто компаниас бид нотлох баримтын хүрээнд ирсэн албан тоотыг харуулж байна. Рио Тинто компаниас 2025 оны 5 сарын 30-нд энэ бас олон нийтэд гарсан байна лээ. Рио Тинто компаниас зээлийн хүүгийн хэлэлцээр дээр бид хэлэлцээрт ороход бэлэн байна гэсэн албан тоот ирсэн байгаа юм. Эрдэнэс Оюу толгой компани руу хаяглаж ирсэн байна. Тэгэхээр Рио Тинто компаниас зээлийн хүүгийн, хувь нийлүүлэгчдийн зээлийн хүү дээр бид хэлэлцээрт ороход бэлэн байна гэсэн бол Монголын тал энэ боломжоо яаралтай ашиглаад, хэлэлцээрт л орох ёстой юм. Энэ дээр ерөөсөө цаг хугацаа алдалгүйгээр л энэ хэлэлцээртээ ороод, хамгийн боломжит хувилбараа та бүхэн хэлэлцээрийн түвшиндээ яриад л, энийг бид заавал өөрчлөх ёстой шүү 1 дүгээрт.

2 дугаарт эндээс харахад, гарын үсэг зурснаас энэ харахад нөгөө энэ Хувь нийлүүлэгчдийн гэрээ байгуулсан хуулийн этгээдүүд байгаа. Энэ Айвенхоу Оюу толгой /Ви Ви Ай/ гээд, энэ дандаа нөгөө цаасны компаниуд шүү дээ. Оюу толгой Нидерланд гээд энэ дээр бол хүн байдаггүй. Нидерланд гээд энэ дандаа цаасны компани. Тэгэхээр энэ цаасны компанитай гэрээ хэлэлцээр хийнэ гэж юу байх вэ, шууд 100 хувийн эзэмшигч Рио Тинто компанитай хэлэлцээрт орох ёстой.

Нэг зүйлийг энэ дээр завшаан болгоод сануулмаар байна л даа. Хэлэлцээрт орохдоо та бүхэн шууд Рио Тинто компанийн Лондон оффис, Рио Тинто компанийн яг зэсийн группийг нь хариуцаж байгаа шууд том захиралтай хэлэлцээрт орох ёстой шүү. Katie Jackson гээд зэсийн группийн гүйцэтгэх захирал байгаа. Тэрнээс биш энэ Оюу толгой Нидерланд /Ви Ви Ай/ гарын үсэг зурсан учраас энэ цаасны компанийн захиралтай хэлэлцээрт орно гэж байхгүй шүү дээ. Эсвэл Рио Тинто Монголиа гээд, эсвэл Монголд байгаа нэг төлөөлөгчийн газрын, 2 ажилтантай төлөөлөгчийн газартай хэлэлцээрт орно гэж байхгүй. Тэгэхээр энэ дээр цаг хугацаа алдахгүйн тулд шууд шийдвэр гаргах түвшний хүмүүстэй албан тоотоор яг Сангийн сайд хариуцаж байгаагийн хувьд шууд захидлаар харилцаж, яаралтай хэлэлцээрт орох ёстой байгаа. Энэ дээр цаг хугацаа алдалгүй, яаралтай хэлэлцээрт орохыг л бид бүхэн ерөөсөө хүлээж байгаа.

Тэрнээс биш бид бүхэн энэ хурал дээр та бүхний ямар тактик баримталж, ямар тактикаа явуулж, алийг нь түрүүн явуулж, зээлийн хүүгээ хэд болгох талаар парламентын түвшинд бид авч үзэхгүй. Бид парламент дээр Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороон дээр хяналт шалгалтын асуудлаа л бид ярина. Хэлэлцээрт орох субъект бол Монгол Улсын Засгийн газар. Зээлийн хүү дээр Сангийн сайд орно гэж ахалж орно гэж Ерөнхий сайдын захирамж гарсан байна.

Сангийн сайдын танилцуулсан танилцуулгатай холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье? Зулпхар гишүүнээр тасалъя. Болормаа гишүүний микрофон.

Э.Болормаа: Түрүүн өмнөх асуудал дээр хэлсэн юмаа давтаад хэлье. Яагаад гэвэл Сангийн сайд байгаагүй, Эрдэс баялгийн сайд байсан учир. Энэ хэлэлцээрт Зээлийн хүүгийн хэлэлцээрт орохдоо Улсын Их Хурлаас гаргасан 92 дугаар тогтоол болон 103 дугаар тогтоолынхоо ажилтай уялдуулаач гэж хүсмээр байна. Ялангуяа энэ Монгол Улсад ирэх өгөөжийн дийлэнх, бидний Үндсэн хуульд заасан энэ өгөөжийн дийлэнх гэдгийн томьёоллыг л та бүхний тооцоогоор гаргаж ирнэ. Яаж бид энэ Оюу толгойнхоо гэрээгээр Монгол Улсад өгөөжийн дийлэнх нь ирэх вэ л гэдгийг гаргаж байгаа учир энэ дээр онцгойлон дахин хэлье.

Энэтэй холбоотойгоор нэг асуух асуулт байна. Бид Оюу толгойн төслийг зөвхөн Оюу толгой, Рио Тинто буюу Монгол Улс хоёрын хоорондох гэрээ гэж хардаг боловч маш олон банк, санхүүгийн байгууллагуудын оролцоотой ийм томоохон төсөл байдаг. Миний мэдэхийн жишээлбэл Дэлхийн банк группийн мега буюу баталгаа өгдөг энэ байгууллагынхаа хамгийн том төсөл нь манай Монгол дахь Оюу толгой төсөл байдаг. Тэгэхээр энэ хэлэлцээртээ та бүхэн энэ бусад хөрөнгө оруулагч нар болон энэ олон улсын банк, санхүүгийн байгууллагатай холбогдож байгаа юу? Тэдгээрийн байр суурийг оруулах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Яагаад гэвэл Дэлхийн банк жишээлбэл үндсэн зорилго нь, тэр байгууллагын үндсэн зорилго бол дэлхийн ядуурлыг бууруулж, энэ хөгжлийг сайжруулах байтал ийм хэмжээний хүүгийн зөрөө, ийм хэмжээний санхүүгийн хувьд шулуухан хэлэхэд мөнгө хүүлэлт шиг ийм зүйлийг хэрхэн зөвшөөрч байгааг би ойлгохгүй байна л даа. Тэгэхээр тэдгээр байгууллагуудтайгаа хэлэлцсэн үү гэж асууя?

О.Батнайрамдал: Болормаа гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ, аль микрофон? Ойлголоо. Болормаа гишүүний асуултад нэмэлт хариулт өгчихье. Далд уурхайн бүтээн байгуулалт санхүүжилт маш том санхүүжилт явсан. Тэрний нэг оролцогчид бол Дэлхийн банкны мега томоохон төслийн grantive буюу баталгаа гаргаж өгсөн. Тэгэхээр энэ Рио Тинтогоос гадна маш олон оролцогч талууд байгаа, олон улсын байгууллагууд байгаа. Тэдний хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулалтууд эрсдэлийн хувьд бидэнд хамааралтай гэсэн үг.

Өнөөдөр Оюу толгой төслийг санхүүжилтийн бүтцийг нь аваад үзвэл энэ чинь бараг 82-оос 85 хувь нь зээлийн санхүүжилт байдаг юм шүү дээ. Зүгээр энгийн санхүүгийн бүтэц нь эрүүл компанийн хувьд энэ харьцаа 70, 30 байдаг. Зээл нь бүүр хэтрээд, хэтрээд, 75-аас илүү гарахыг хэтрэлт гэж тооцдог. Гэтэл энэ төсөл хэтэрхий зээлдээ баригдчихсан, санхүүгийн бүтцийн хувьд дэндүү гажуудчихсан төсөл байхгүй юу. Яагаад гэхлээр зээл гэхээсээ илүүтэйгээр зээлийн хүү нь хэтэрч явсаар байгаад, давхар зээлд тооцогддог учраас, давхар хүү тооцогддог учраас ингээд зээлийн бүтэц нь гажуудчихсан. Тэгэхээр энэ Дэлхийн банкны мега төсөл ч гэсэн энэ асуудал дээр бас л өөрсдийнхөө байр суурь илэрхийлэх ёстой, байр суурь байгаа байх гэж бодож байна. Тэгэхээр энэ бүхнийг та бүхэн зээлийн хүүгийн хэлэлцээртээ тооцож үзээсэй л гэж Болормаа гишүүн хэлээд байна. Болормаа гишүүн нэмэлт тодруулах уу? Болормаа гишүүн нэмэлт тодруулъя.

Э.Болормаа: Сангийн сайдаа, энэ нөгөө зөвхөн зээлийн хүү ярьж байгаа боловч уул нь энэ Түр хороо амьхандаа дэм болох гээд л саналууд хэлж, асууж байгаа юм л даа. Бид энэ олон нийтийн Түр хорооны хурал хийж байгаа учир. Тэгэхээр энэ олон талын энэ зээлдэгчид, ялангуяа олон улсын банк, санхүүгийн байгууллагууд зүгээр хувийн банкныг бодвол энэ чинь өөр хөгжлийн бодлогын

зорилттой байгууллагууд шүү дээ. Тэгэхээр тэднийгээ оролцуулах нь магадгүй дэмтэй болов уу. Энэ Монгол Улсад ирэх энэ зээлээс болж ийм санхүүгийн дарамт ирж байгаа учир энэ зөв байна уу гэдэг талаас нь тэрийгээ оролцуулаач гэдэг ийм санал гэж та бүхэн хүлээж аваарай. Та бүхний асуулт биш юм шүү. Та бүхэн ажлын хэсгийнхээ ажлынхаа явцдаа юмыг оролцуулбал дэм болж магадгүй гэж санал хэлж байгаа юм шүү.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүний микрофон өгье.

С.Зулпхар: Баярлалаа. Ажил их, тийм ажил хэрэгч тал талаасаа явж байгаад их талархалтай байна. Нөгөөтээгүүр яах вэ бид ер нь хэвлэл мэдээллээр нэг зүйлийг ярьж байх ёстой юм шиг байгаа юм. Гаднын хөрөнгө оруулагчдыг бид нэг үргээх гээд байгаа юм шиг, эсхүл гаднын хөрөнгө оруулагчдын эрх ашигт бид ямар нэгэн байдлаар халдсан юм шиг ийм байдал ойлголт, буруу ойлголт явах ёсгүй гэдгийг тал талдаа бид мэдэж байгаа. Заримдаа тийм байдлаар асуудалд ханаж байна гэсэн өрөөсгөл ойлголт явдаг шүү л гэж байгаа юм.

Харин эсрэгээрээ зүгээр энэ дээр нэг ийм л зүйл байгаа шүү дээ. Бид ингээд 2 сар гаруй ажилласан Түр хорооны хувьд энд ер нь энэ төслийн хүрээнд эрх тэгш байх, харилцан ашигтай байхын зарчим дээр л жоохон асуудал байгаа учраас энийгээ л засаад явъя гэдэг ийм зүйл ярьж байгаа юм. Та бүхэн хэвлэлээр ингээд мэдээллүүд өгөөд явсан байна лээ. Сүүлийн 1 сарын дотор та бүхэн асуудалд их идэвхтэй, ажил хэрэгч байдлаар хандаад, бидний байр суурь яг яг ижилхэн байна лээ, байх ч ёстой л доо. Тэрэнтэй адилхан хөрөнгө оруулагч тал ч гэсэн энийг тэгж зөвөөр ойлгох ёстой гэж ойлгож байгаа юм. Бид цаашдаа Монгол Улсад маш олон хөрөнгө оруулагчид ирж, томоохон төслүүдийг бидэнтэй хамт хэрэгжүүлээч гэдэг ийм хүсэлтийг өөрсдөө тавьж байгаа шүү дээ. Ийм бид санаачилга гаргаач гэдэг зүйлийг ч гэсэн ярьж байгаа. Энэ үүднээс нь энийг зориуд тэмдэглэе. Хэвлэл мэдээлэл ч гэсэн энийг цааш нь олон улсын тэр хөрөнгө оруулагчдад хүрэх ёстой байх гэж бодож байна. 2 асуулт байна.

Эхнийх нь ингээд ямар ч байсан Жавхлан сайдаар ахалсан ажлын хэсэг маань ажиллаад, хэлэлцээрээ бэлдэж байгаа юм байна. Тэгэхлээр зэрэг бидэнд нэг хугацаа байгаа шүү дээ 2025 оны 12 сарын 31 гэсэн. Энэ хугацаанаас өмнө хэлэлцээр эхлэх нь гэдэг ойлголттой боллоо, 1 дүгээрт энэ зөв үү?

2 дугаарт бидэнд эргэлзээ байсан. Энэнээс өмнө л энэ хэлэлцээрийг байгуулж дуусахгүй бол болохгүй гэдэг нэг тийм өрөөсгөл ойлголт байгаад байсан л даа. Гэхдээ бид явцад нь юу гэж ойлгосон гэхлээр зэрэг хэлэлцээр эхэлсэн бол энэ цаашаа үргэлжлээд ямар хугацаанд хийгдэх юм 2 сар юм уу, 3 сар юм уу энэ хугацаанд хийгдчих учраас ямар нэгэн жишээ нь гэрээн дээр байсан жишээ нь тэр зохицуулалт зөрчигдөхгүй юм гэж ойлгож байгаа. Энэ зөв үү гэсэн ийм 2 асуулт байна?

О.Батнайрамдал: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Сангийн сайд Жавхлан, 3 номерын микрофон.

Б.Жавхлан: Эхлээд нөгөө Болормаа гишүүний түрүүний санал дээр санал 100 хувь санал нийлж байна. Ер нь энэ stakeholders-тай бид заавал ярилцах ёстой. Тэд нар ч гэсэн бас эрсдэлээ харж тооцоолж байгаа шүү дээ. Өчигдөр жишээ нь бид IFC-тэй энэ асуудлаар мөн ярилцсан. Зүгээр бид мэдээлэл солилцох түвшинд ажиллана. Тэрнээс биш яг энэ, энэ чинь юуны төслийн зээл, хувь нийлүүлэгчдийн

зээл гээд 2 өөр бүлэг зээлүүд байгаа юм. Тийм учраас хэлэлцээрийн талд нь мэдээж оролцохгүй байгаа. Гэхдээ бид мэдээлэл солилцох түвшинд 2 талдаа эрсдэлээ бууруулах түвшинд хамтраад ажиллана гэдгийгээ харилцан илэрхийлсэн байгаа.

Зулпхар гишүүний асуултад хариулъя. Таны ярьж байгаа зөв. Энэ 12 сарын 31-нээс өмнө хэлэлцээрээ эхлүүлсэн байх ёстой. Зүгээр яах вэ энэ удаа би зүгээр ерөнхий нэг мэдээлэл өгье. Бид 3 асуудал дээр онилж ажиллана. Зээлийн хүүгээ бууруулна, 2 дугаарт энэ яагаад ийм мэдэхгүй, ямар үндэслэлээрээ мэдэхгүй 7 жил тутам update хийнэ гэхихсэн байгаа юм. Юунаас тооцож 7 жил гаргасан юм бүү мэд. Тэр 7 жил гэдэг нь бидэнд маш хохиролтой байна. Тийм учраас 7 жилийг буулгана, ядаж 3 жил рүү орж ирнэ. 3 жил гэдэг ямар хугацаа вэ гэхээр бид 3 жил тутам Их Хурал дээр өрийн удирдлагын дунд хугацааны стратегиа батлуулж явдаг. Тэгэхээр энэ хүрээлэл рүүгээ оруулж ирэх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол 7 жил гэдэг чинь үндсэндээ ингээд сая өнгөрсөн 4 жилийн парламент энийг ерөөсөө мэдээгүй, сөгөөгүй, дурдаагүй ингээд өнгөрчхөж байгаа байхгүй юу. 7 жил гэхээр энэ чинь дор хаяж ингээд нэг парламент, зарим тохиолдолд энэ чинь ингээд бүүр 4, 4 жилийн хугацаанд их сонин болчихоод байгаа юм. Энийг тэгээд богиносгоно.

Дараа нь энэ нийлмэл хүү буюу хүүгээс хүү тооцдог ийм compound, ийм загвараар хүү тооцсоор байгаад өнөөдөр энэ чинь ингээд анхны нөгөө 6 тэрбум доллар чинь ингээд 11, 12 хүрээд даблдчихаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл 3 түгжээ хийгээд хаячихсан хүү нь өндөр, 7 жил энийгээ эргэж харахгүй, тэгсэн мөртөө эргэж харахгүй энэ 7 жилийн хугацаанд нь нийлмэл хүүгээр хүүгээс хүү тооцно гээд явчихсан. Тэгээд ийм 3 асуудал дээр өөрчлөхөөр ингэж ажиллана. Тийм учраас хэлэлцээр бол мэдээж 12 сарын 31-нээс өмнө ч юу байх вэ одоо энэ эхэлчихсэн явж байгаа, компанийн түвшинд эхэлчихсэн явж байгаа. Энэ дээр Засгийн газраас хүч нэмж хангахаар Сангийн сайд энэ хүүтэй, хүүгийн хэсгийг нь ахал, Уул уурхайн сайд тэр Онтрэ-тэй хэсгийг нь ахал. Ингээд ямар ч байсан зүгээр бид ажил дээрээ ирээд хэлэлцээрээ амжилттай болгохын тулд нэг яг чиглэлийн яаман доороо буюу Уул, уурхайн яам доор нь бодлогуудаа нэгтгээд явъя гэдэг дээр санал нийлчхээд ингээд явж байна.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Түр хорооны тэмдэглэл явж байгаа учраас зориуд нөгөө тэмдэглүүлэх үүднээс энийг зориуд асууж ахиж нөгөө нягталж авмаар байна, нотолж авмаар байна гэж байгаа юм. Хэлэлцээр эхэлчихлээ. Миний 2 дахь асуулт болохоор зэрэг бид ингээд 12 сарын 31-нд хэрвээ хэлэлцээр чинь сунжраад амжихгүй байсан ч гэсэн он гарлаа гэхэд манай хэлэлцээр үргэлжилж байгаа учраас хугацаа дуусаагүй, бид хэлэлцээр явж байгаа гэдэг ийм ойлголтоороо хэлэлцээрээ цааш нь үргэлжлүүлээд дуусгана гэж ойлгож байгаа зөв үү гэж байгаа юм? Ер нь бол би ингэж бодоод байгаа шүү дээ. Багтана, хугацаандаа бол багтана гэж бодож байгаа юм. Багтаагүй нөхцөлд энэ чинь В жишээ нь вариант гараад ирлээ шүү дээ, В вариант гараад ирлээ гэж бодвол бид хугацаа үргэлжилж байгаа, хэлэлцээр үргэлжилж байгаа гээд хэлэлцээрээ дуусгаж авна л гэдэг энийг тэмдэглэлд бүүр зориуд үлдээмээр байгаа юм.

О.Батнайрамдал: 6 номерын микрофон Ганхүү захирал.

Э.Ганхүү: Та бүхний энэ өдрийн мэнд хүргэе. Хэлэлцээрт бид бүхэн 5 сард Рио Тинто-гоос хариугаа авчихсан байгаа. Өнөөдрийн байдлаар бид яг албан ёсны хэлэлцээрийн баг Засгаас томилогдоогүй байгаа хэдий ч Эрдэнэс Монгол, Эрдэнэс

Оюу толгой компани бол үндсэн Рио Тинто, Оюу толгойтой техникийн уулзалтаа хийгээд, яг ямар шаталбараар, яаж явах вэ гэдэг дээр тогтсон байгаа. Хэлэлцээрийн баг ороод, ажилдаа ороод явбал бид бүхэн хэлэлцээрийнхээ тактикийг, хэлэлцээрийнхээ удирдамжийг аваад, энэ хэлэлцээр хийх шатдаа бидний хувьд зээлжих зэрэглэл тогтооно ч гэх юм уу, энэ дээр хэчнээн хугацаа шаардах юм гэдгээ харилцан хамаарал талууд хэлэлцээртээ тохирсны дагуу хэлэлцээр нэгэнт эхэлчихвэл гэрээ байгуулах юм уу, хэлэлцээрийн өгсөх шатдаа, тэр явах процессынхоо хэлэлцээрийнхээ шатанд гарсан асуудлынхаа дагуу хугацаа сунгах нь нээлттэй гэж үзэж байгаа.

О.Батнайрамдал: Болчихсон уу Зулпхар гишүүн? Хамгийн гол нь цаг хугацаандаа багтаарай л гэж байгаа юм. Цаг хугацаандаа багтаарай. Нөгөө тал гэрээний эрх дууссан шүү дээ, цаашаа үргэлжлэх боломжгүй гэдэг хариу хэлэх вий л гэж байгаа юм. Тэгээд Улсын Их Хурал дахь Хянан шалгах түр хороо, Жавхлан сайдаа бид таныг хэлэлцээр дээр дэмжиж ажиллана. Бид бүгдээрээ Монгол Улсын эрх ашгийн талд, Монгол Улсын Улсын Их Хурал, тэр дундаа Хянан шалгах түр хороо, Засгийн газар бид бүгдээрээ Монгол Улсын эрх ашгийг төлөөлж байгаа. Бид бүхэн та бүхнийг дэмжиж ажиллана. Тэгээд хамгийн гол нь та бүхэн маань цаг хугацаандаа багтаж, энэ дээр үр дүн гаргаасай л гэж бид чин сэтгэлээсээ хүсэж байгаа.

Тэгээд сая Дамдинням сайд ерөнхийдөө нэгдсэн удирдлагаар хангаж Засгийн газраас ажиллана гэж би бүхэн ойлголоо. Бид цаашдаа хуралдаад явахад ч гэсэн хамгийн гол нь бидний хүсэж байгаа зүйл яг ахалж байгаа сайд маань яг хуралдаан дээрээ байж, асуудлаа бид бүхэнтэй хамтдаа ярьж яваач гэж байгаа юм. Тэгэхээр тэр амлалтыг бол сая Дамдинням сайд өгсөн гэж ойлгосон. Тэгэхээр та ч гэсэн хуралдаандаа бид бүхэнтэй хамт сууж, мэдээллээ солилцож яваарай гэж хүсэж байгаа юм. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Тэгээд хэлэлцээрийн багт амжилт хүсье. Амжилт хүсье. Баярлалаа.

15.49 цаг

Өнөөдрийн Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны хэлэлцэх асуудал үүгээр дуусаж байна. Ажлын хэсэгт баярлалаа. Хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА